**НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Багахангай дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: НТАГ-2026/235/НА-СТА-ТШЗ**


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2026 он | Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер Х.Түвшинбаяр<br>Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: С.Гантөгс<br>Утас: 315558 Цахим хаяг: gantugss@audit.gov.mn<br><br>Ахлах аудитор: Н.Бадамхатан<br>Утас: 325093 Цахим хаяг: badamkhatann@audit.gov.mn<br><br>Аудитор: Ц.Цэнд-Аюуш Цахим хаяг: tsend-ayushts@audit.gov.mn<br>Утас: 325093 |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.02.25 № 214

танай ______________-ны № ______________-т

БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА БӨГӨӨД АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА М.ДАВААНЯМ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Багахангай дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Бага насны хүүхдийг зам тээврийн осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, тэдний аюулгүй байдлыг хангах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах орчин нөхцлийг бүрдүүлэх зорилгоор гэр хорооллын авто замын бүсэд гэрлэн гарц бүхий лед гэрэлтүүлгийг хийсэн байна.

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Багахангай дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь тайлант онд гадаад албан томилолтын зардалд 3.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

1426050281

C:\Users\narangua.j\Desktop\Бичиг хэрэг 2026\...\2026.02.25 Dugnelt....docx

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

**Бусад асуудал**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 35 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, бүрэн хэрэгжүүлж ажилласан гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамруулаагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ

C:\Users\narangua.j\Desktop\Бичиг хэрэг 2026\2026word\ywsan bichig\2026.02.25 Dugnelt .docx

# 1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 1.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.* /төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **43,400,477.00** | **42,960,388.82** |
| **33** | **АВЛАГА** | 4,571,712.00 | 997,293.82 |
| **335** | **Бусад авлага** | 4,571,712.00 | 997,293.82 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 4,571,712.00 | 997,293.82 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 38,828,765.00 | 41,963,095.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 38,828,765.00 | 41,963,095.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,624,830.00 | 1,878,560.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 34,988,635.00 | 39,198,235.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 1,215,300.00 | 886,300.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **51,139,208.36** | **205,529,322.20** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 51,139,208.36 | 205,529,322.20 |
| **392** | **Биет хөрөнгө** | 50,896,308.30 | 205,451,422.02 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 5,419,959.90 | 5,419,959.90 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -1,161,419.76 | -1,354,989.72 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 27,200,000.00 | 199,500,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -27,200,000.00 | -36,772,222.24 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 73,785,553.00 | 73,310,553.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -44,388,349.17 | -51,130,408.61 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 36,953,963.00 | 35,772,890.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -19,713,398.67 | -16,901,304.75 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 242,900.06 | 77,900.18 |
| 39301 | Программ хангамж | 605,000.00 | 605,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -412,499.94 | -577,499.82 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 50,400.00 | 50,400.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **94,539,685.36** | **250,882,766.58** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **94,539,685.36** | **250,882,766.58** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 94,539,685.36 | 250,882,766.58 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 22,440,096.00 | 22,440,096.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 22,440,096.00 | 22,440,096.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 68,710,936.30 | 225,054,017.52 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 68,710,936.30 | 68,493,136.30 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 156,560,881.22 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 3,388,653.06 | 3,388,653.06 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **94,539,685.36** | **250,882,766.58** |

## 1.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.* /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **939,616,582.75** | **1,359,615,980.65** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **62,433.00** | **172,383,798.44** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 62,433.00 | 172,383,798.44 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 62,433.00 | 172,383,798.44 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **939,554,149.75** | **1,187,232,182.21** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 112,944,450.00 | 189,852,470.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 112,944,450.00 | 189,852,470.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 826,609,699.75 | 997,379,712.21 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 826,609,699.75 | 997,379,712.21 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **935,000,537.94** | **1,205,152,804.71** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **935,000,537.94** | **1,205,152,804.71** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 883,852,875.44 | 1,184,627,304.69 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 518,404,319.68 | 675,934,417.32 |
| 210101 | Үндсэн цалин | 297,360,579.86 | 284,649,659.18 |
| 210102 | Нэмэгдэл | 102,638,010.42 | 176,903,413.46 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 53,632,285.00 | 130,860,969.92 |
| 210104 | Урамшуулал | 64,773,444.40 | 83,520,374.76 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 65,719,311.90 | 84,485,443.87 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 45,348,916.62 | 57,650,388.69 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,398,941.86 | 6,827,827.52 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,871,651.74 | 3,408,830.80 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,205,655.77 | 3,392,030.71 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,894,145.91 | 13,206,366.15 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 3,206,880.00 | 3,206,880.00 |
| 210302 | Түлш, халаалт | 506,880.00 | 506,880.00 |
| 210304 | Байрны түрээс | 2,700,000.00 | 2,700,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 35,728,673.01 | 32,924,765.62 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,065,900.00 | 5,906,840.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,648,457.00 | 9,891,626.62 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,674,282.01 | 4,765,569.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 507,600.00 | 253,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 24,832,434.00 | 12,106,930.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,651,000.00 | 19,979,700.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | 00.00 | 16,397,700.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210702 | Дотоод албан томилолт | 4,651,000.00 | 3,582,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 142,944,542.00 | 334,470,098.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 141,853,990.00 | 331,119,670.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 372,600.00 | 1,030,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 67,952.00 | 521,828.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 600,000.00 | 1,798,100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 110,343,148.85 | 30,979,044.32 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 94,356,670.00 | 4,833,664.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 00.00 | 80,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 15,986,478.85 | 26,065,380.32 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 51,147,662.50 | 20,525,500.02 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 34,147,662.50 | 20,525,500.02 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 2,700,000.00 | 4,860,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 2,383,000.00 | 3,396,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 24,071,662.50 | 8,354,500.02 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,993,000.00 | 3,915,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **4,616,044.81** | **154,463,175.94** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 56,150.00 | 549,250.28 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 56,150.00 | 549,250.28 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (56,150.00) | (549,250.28) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **4,559,894.81** | **156,560,881.22** |

## 1.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.* /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **939,554,149.75** | **1,187,232,182.21** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **939,554,149.75** | **1,187,232,182.21** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 112,944,450.00 | 189,852,470.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 112,944,450.00 | 189,852,470.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 826,609,699.75 | 997,379,712.21 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 826,609,699.75 | 997,379,712.21 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **939,554,149.75** | **1,175,916,582.21** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **939,554,149.75** | **1,175,916,582.21** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **887,789,487.25** | **1,155,135,082.19** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 519,266,319.24 | 675,934,417.32 |
| 210101 | Үндсэн цалин | 269,083,067.38 | 284,649,659.18 |
| 210102 | Нэмэгдэл | 113,039,000.00 | 176,903,413.46 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 65,481,151.86 | 130,860,969.92 |
| 210104 | Урамшуулал | 71,663,100.00 | 83,520,374.76 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 67,334,950.00 | 84,485,443.87 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 46,512,150.00 | 57,650,388.69 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,205,700.00 | 6,827,827.52 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,613,000.00 | 3,408,830.80 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,592,800.00 | 3,392,030.71 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,411,300.00 | 13,206,366.15 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 3,206,880.00 | 3,206,880.00 |
| 210302 | Түлш, халаалт | 506,880.00 | 506,880.00 |
| 210304 | Байрны түрээс | 2,700,000.00 | 2,700,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 20,459,436.01 | 22,372,169.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,139,630.00 | 3,579,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,600,000.00 | 8,175,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,892,282.01 | 4,811,469.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 507,600.00 | 253,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,319,924.00 | 5,552,200.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5,835,900.00 | 890,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 00.00 | 850,000.00 |
| 210602 | Тавилга | 1,899,600.00 | 40,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 8,651,000.00 | 15,979,700.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210701 | Гадаад албан томилолт | 4,000,000.00 | 12,397,700.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,651,000.00 | 3,582,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 164,035,002.00 | 344,136,508.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 162,944,450.00 | 340,697,080.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 372,600.00 | 1,030,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 67,952.00 | 521,828.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 600,000.00 | 1,887,100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 99,000,000.00 | 8,129,964.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 99,000,000.00 | 7,849,964.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 00.00 | 280,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **51,764,662.50** | **20,781,500.02** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 34,764,662.50 | 20,781,500.02 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 2,700,000.00 | 4,900,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 3,000,000.00 | 3,446,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 24,071,662.50 | 8,354,500.02 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,993,000.00 | 4,081,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **-** | **11,315,600.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **-** | **11,315,600.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **11,315,600.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | 11,315,600.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | | 11,315,600.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-** | **(11,315,600.00)** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 1.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлтийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.* /төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 22,440,096.00 | 3,388,653.06 | 64,151,041.49 | 89,979,790.55 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **22,440,096.00** | **3,388,653.06** | **64,151,041.49** | 89,979,790.55 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | - |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 99,133,515.86 | 99,133,515.86 |
| **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **22,440,096.00** | **3,388,653.06** | **68,710,936.30** | **94,539,685.36** |
| **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **22,440,096.00** | **3,388,653.06** | **68,710,936.30** | **94,539,685.36** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | (217,800.00) | (217,800.00) |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **22,440,096.00** | **3,388,653.06** | **68,493,136.30** | **94,321,885.36** |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | - |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 156,560,881.52 | 156,306,981.22 |
| **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **22,440,096.00** | **3,388,653.06** | **225,054,017.52** | **250,882,766.58** |

## 1.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.* /төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь |
|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,044,459,500.00 | 997,379,712.21 | 92% |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,044,459,500.00 | 997,379,712.21 | 92% |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,022,364,300.00 | 976,598,212.19 | 92% |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 703,975,000.00 | 675,934,417.32 | 91% |
| 210101 | Үндсэн цалин | 292,635,400.00 | 248,649,659.18 | 85% |
| 210102 | Нэмэгдэл | 183,701,500.00 | 176,903,413.46 | 96% |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 133,229,000.00 | 130,860,969.92 | 98% |
| 210104 | Урамшуулал | 94,409,100.00 | 83,520,374.76 | 88% |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 87,931,600.00 | 84,485,443.87 | 96% |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 59,838,000.00 | 57,650,388.69 | 96% |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,039,900.00 | 6,827,827.52 | 97% |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,529,600.00 | 3,408,830.80 | 97% |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,510,000.00 | 3,392,030.71 | 97% |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,014,100.00 | 13,206,366.15 | 94% |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 3,410,400.00 | 3,206,880.00 | 94% |
| 210302 | Түлш, халаалт | 710,400.00 | 506,880.00 | 71% |
| 210304 | Байрны түрээс | 2,700,000.00 | 2,700,000.00 | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 23,164,800.00 | 22,372,169.00 | 97% |
| 210401 | Бичиг хэрэг | 3,650,000.00 | 3,579,700.00 | 98% |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8,175,000.00 | 8,175,000.00 | 100% |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5,280,000.00 | 4,811,469.00 | 91% |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 507,600.00 | 253,800.00 | 50% |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,552,200.00 | 5,552,200.00 | 100% |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 6,880,000.00 | 6,874,600.00 | 100% |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 5,000,000.00 | 4,999,600.00 | |
| 210602 | Тавилга | 1,880,000.00 | 1,875,000.00 | 100% |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 17,097,700.00 | 15,979,700.00 | 93% |
| 210701 | Гадаад албан томилолт | 12,397,700.00 | 12,397,700.00 | |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,700,000.00 | 3,582,000.00 | 76% |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 171,774,800.00 | 159,615,038.00 | 93% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 168,209,000.00 | 156,175,610.00 | 93% |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,040,500.00 | 1,030,500.00 | |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 567,700.00 | 521,828.00 | 92% |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 50,000.00 | | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,907,600.00 | 1,887,100.00 | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 8,130,000.00 | 8,129,964.00 | 100% |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,850,000.00 | 7,849,964.00 | 100% |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 280,000.00 | 280,000.00 | |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 22,095,200.00 | 20,781,500.00 | 94% |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 22,095,200.00 | 20,781,500.00 | 94% |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 4,900,000.00 | 4,900,000.00 | |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 3,500,000.00 | 3,446,000.00 | |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 8,395,200.00 | 8,354,500.00 | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,300,000.00 | 4,081,000.00 | 77% |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,044,459,500.00 | 997,379,712.21 | 95% |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,044,459,500.00 | 997,379,712.21 | |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 1,044,459,500.00 | 997,379,712.21 | |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 15 | 15 | 100% |
| 620001 | Удирдах ажилтан | 3 | 3 | 100% |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 10 | 10 | 100% |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 2 | 2 | 100% |

## 1.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.* /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **189,852,470.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **189,852,470.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 189,852,470.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 189,852,470.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 189,852,470.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 189,852,470.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 189,852,470.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 189,852,470.00 |

## 2. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайлангаарх эцсийн үлдэгдлийг санхүүгийн тайлангаарх тодруулгын эцсийн үлдэгдэлтэй тулган шалгахад зөрүүтэй илэрхийлэгдсэн байна. | 1 | 217.8 | | | | | 1 | 217.8 | | | | |
| Үндсэн хөрөнгийн элэгдлийг давтан тооцоолоход тээврийн хэрэгслийн элэгдлийг илүү тооцож тайлагнасан байна. | 1 | 2,393.1 | | | | | 1 | 2,393.1 | | | | |
| Шатахууны тооцооллыг шалгахад урамшууллыг орлогод бүртгээгүй байна. | 1 | 98.6 | | | | | 1 | 98.6 | | | | |
| Шагнал урамшууллын зардлыг түүвэрлэн шалгахад 235.9 мянган төгрөгийн ХХОАТ-ын авлагатай тайлагнасан байна. | 1 | 235.9 | | | | | 1 | 235.9 | | | | |
| **Дүн** | **4** | **2,945.4** | | | | | **4** | **2,945.4** | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Мөнгөн хөрөнгийг түүвэрлэн үзэхэд анхан шатны баримтын бүрдэл дутуу гүйлгээ хийсэн байна. | 1 | 3,166.5 | | | | | 1 | 3,166.5 | | | | |
| Жилийн эцсийн тайлангаар дансны авлагатай гарсан байна. | 1 | 979.3 | | | | | 1 | 979.3 | | | | |
| Дүн | 3 | 4,145.8 | | | | | 3 | 4,145.8 | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | | | | | |
| Төсвийн хөрөнгөөр шаардлагагүй материалыг их хэмжээгээр орлого авч нөөцөлсөн байна. | 1 | 2,021.1 | | | 1 | 2,021.1 | | | | | | |
| Худалдан авах ажиллагааны тайланг шилэн дансанд байршуулаагүй байна. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| Шилэн дансны цахим хуудсанд цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээг хуулийн хугацаа хоцроож мэдээлсэн байна. | 1 | | | | | | 1 | | | | | |
| Дүн | **3** | **2,021.1** | | | **1** | **2,021.1** | **3** | - | | | | |

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 119/А0271270 Улаанбаатар хот

НТАГ-2026/235/НА-СТА-ТШЗ

**Зөрчил арилгах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Багахангай дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.Үүнд:

Төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл, нөөцлөх шаардлагагүй материалыг их хэмжээгээр орлого авч 2,021,100.00 *(хоёр сая хорин нэгэн мянга нэг зуу)* төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д *"нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх"*, Төсвийн тухай 6 дугаар зүйлийн 6.4.1 *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"*, 16 дугаар зүйлийн 16.5.5 *"батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"*, гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д *"Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол"* заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл, нөөцлөх шаардлагагүй материалыг их хэмжээгээр худалдан авсан зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх. Хэрэгжилтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн Аудитын газарт ирүүлэх;

1426990051

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Багахангай дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны дарга (М.Давааням), ахлах нягтлан бодогч (Ц.Алтанцэцэг) нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН1:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ

АУДИТОР Ц.ЦЭНД-АЮУШ

---

1 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар